МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШУУД НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ НЭГ ТАЛТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

1. Нийтлэг үндэслэл

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх/МУТС/-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан арга хэлбэрээр хэрэгжүүлэх үүрэгтэй. Мөн хуулийн 14.1-д зааснаар Мэдээлэх үүрэгтэй этгээд нь түүний төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл түүнтэй адилтгах удирдлагаас баталсан МУТС-тэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байх үүрэгтэй. Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр нь Мэдээлэх үүрэгтэй этгээдийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцсэн байх ба мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг хангасан байх шаардлагатай.

Энэхүү зөвлөмжийн зорилго нь Мэдээлэх үүрэгтэй этгээд өөрийн болон салбарын корреспондент харилцаа, бизнесийн үйл ажиллагааны хэвийн байдал, нэр хүндэд сөргөөр нөлөөлж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нэг талт хориг арга хэмжээг[1] зөрчих, түүнийг тойрч гарах оролдлого, үйлдлийг илрүүлэх, гарч болзошгүй эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах зорилгоор дотоод хяналтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж болох арга хэмжээг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, бизнесийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх, эрсдэлийг оновчтой тодорхойлж, эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхийг дэмжихэд оршино.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолоор батлагдсан хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэхүү зөвлөмж хамаарахгүй болно.

2. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь бизнесийн харилцаанд орж байгаа харилцагч, үйлчлүүлэгчийнхээ эрсдэлийг үнэлж, эрсдэлд нь тохирсон байдлаар харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ зорилгоор Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагч, түүний эцсийн өмчлөгчийг тогтоох, эрхэлж буй ажил, бизнес, орлогын эх

[1] Энэхүү нэр томьёог НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл болон олон улсын байгууллагын шийдвэр бус, харин аль нэг улс эсвэл бүлэг улс өөрсдийн санаачилгаар өөр улс, байгууллага, хүний эсрэг дангаар авч хэрэгжүүлж буй хориг, хязгаарлалтыг илэрхийлэх зорилгоор хэрэглэсэн болно. Тухайлбал, ОФАК, Европын холбооны хориг арга хэмжээ гэх мэт.

үүсвэрийн талаар мэдээлэл авах, бизнесийн харилцааны зорилго, данс гүйлгээний зориулалт, утгыг мэдэх, үйл ажиллагаа явуулдаг болон оршин суугаа хаяг, иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг гаргуулан авах үүрэгтэй. Эдгээр мэдээлэл дээр тулгуурлан дараах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

- Харилцагч, түүний эцсийн өмчлөгч, үүсгэн байгуулагчид, төлөөлөн удирдах зөвлөл, шилжүүлэгч/хүлээн авагчийн нэр, хаяг, холбогдох бусад мэдээллийг хоригийн жагсаалттай тулган шалгах,
- Хуулийн этгээдийн өмчлөл, хяналтын бүтэц, толгой болон охин компани, холбоотой этгээдийг шаардлагатай тохиолдолд тодруулах,
- Гүйлгээний утга, зориулалтыг шалгах, хоригт орсон этгээд, бараа бүтээгдэхүүнтэй холбоотой эсэхийг нягтлах,
- Гадаад худалдаа, төлбөр тооцоотой холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг тохиолдолд худалдааны бичиг баримтыг нягтлан үзэх, холбогдох талууд, эцсийн хүлээн авагч, ачаа тээвэрлэлтийн компани, маршрут, бараа, бүтээгдэхүүний үнийн дүн, тоо хэмжээнд нийцгүй, сэжигтэй зүйлс байгаа эсэхийг нягтлах,
- Хоёрдмол зориулалтай бараа бүтээгдэхүүний[2] тухайд эцсийн хэрэглэгчийн мэдээллийг шалгах, дахин экспортлох зөвшөөрөлтэй эсэхийг нягтлах,
- Харилцагч өөр этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, эсхүл өмчлөгч, ашиг хүртэгч, гүйлгээнд оролцогч талуудыг нуун далдлах эрсдэл байгаа эсэхийг тодруулах, дансаа бусдад ашиглуулснаас үүдэн гарах эрсдэл, хариуцлагын талаар харилцагчид сануулах,
- Харилцагчийн гүйлгээ, авч буй үйлчилгээ нь бизнесийн үйл ажиллагааных нь чиглэл, цар хүрээтэй нийцтэй байгаа эсэхийг хянах, ихээхэн хэмжээний өөрчлөлт байгаа тохиолдолд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг нарийвчлан хэрэгжүүлэх.

3. Эрсдэлийн удирдлага, данс, гүйлгээнд хяналт тавих үйл ажиллагааны хүрээнд

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан мэдээлэлд үндэслэн харилцагч, улс орон, газар зүйн байршил, бүтээгдэхүүн,

---

[2] Хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүн гэдэг нь энгийн иргэний болон үйлдвэрлэл, шинжлэх ухааны зорилгоор ашиглагддаг боловч цэргийн болон үй олноор хөнөөх зэвсэг бүтээх, хөгжүүлэхэд ашиглах боломжтой бараа, тоног төхөөрөмж, программ хангамж, технологийг хэлнэ. Улс орнууд худалдааны хяналт, экспортын хяналтын зохицуулалтын хүрээнд хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байдаг. Монгол Улсын тухайд эрх зүйн орчин хараахан бүрдээгүй байгаа ч АНУ, ЕХ тэргүүтэй бусад улсын хоёрдмол зориулалтай бараа бүтээгдэхүүний жагсаалтыг эрсдэлийн удирдлагын хүрээндээ анхааран үзэх боломжтой. АНУ-ын тухайд: https://www.bis.gov/regulations/ear/interactive-commerce-control-list?isExpanded=&category=&keyword=
Европын Холбооны хувьд:
https://policy.trade.ec.europa.eu/news/2026-update-eu-control-list-dual-use-items-2026-09-14_en

үйлчилгээ болон гүйлгээний сувгаас үүдэн гарч болзошгүй эрсдэлийг үнэлж, өөрийн үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшинд тохирсон хяналт, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Тухайлбал, гадаад худалдааны санхүүжилт, гадаад төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, виртуал хөрөнгийн гүйлгээ, арилжаа зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээг хориг арга хэмжээг тойрч гарах зорилгоор ашиглаж болзошгүй тул эдгээртэй холбоотой эрсдэлийг харгалзан шаардлагатай тохиолдолд нэмэлт хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Түүнчлэн мэдээлэх үүрэгтэй этгээд нь хяналт, зохицуулалтын байгууллага, олон улсын байгууллага болон хориг арга хэмжээ тогтоосон улс орнуудаас нийтэлсэн анхааруулга, эрсдэлийн шинж тэмдэг, типологийн судалгаа, тайлан зэрэг мэдээллийг үйл ажиллагаандаа хамаарах хүрээнд ашиглаж, эрсдэлийн үнэлгээ, гүйлгээний хяналт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо тогтмол сайжруулж ажиллах нь зүйтэй.

Энэ хүрээнд дараах мэдээллийн эх сурвалжийг ашиглаж болно. Үүнд:

- **Европын Холбоо:** Хориг арга хэмжээг зөрчих, тойрч гарахтай холбоотой эрсдэлийн шинж тэмдэг, анхааруулга: https://eu-sanctions-compliance-helpdesk.europa.eu/red-flags-mastering-indicators-sanctions-risk_en
- **АНУ-ын Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (FinCEN):** Хориг арга хэмжээг тойрч гарах, экспортын хяналтаас зайлсхийх болон холбогдох санхүүгийн гэмт хэргийн эрсдэлийн талаарх анхааруулга, мэдээлэл: https://www.fincen.gov/resources/advisoriesbulletinsfact-sheets

  Гүйлгээний хэв шинж, эрсдэлийн дохио, IP хаяг зэрэг мэдээллийн зөвлөмж: https://home.treasury.gov/news/press-releases/ssb0644

4. **Гүйлгээ хийх, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах**

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь эрсдэлийн үнэлгээ, харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан баримт мэдээлэл, данс гүйлгээнд тавьсан тусгай хяналтын үр дүнд тулгуурлан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн удирдлагын шийдвэрээр гүйлгээ хийх, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах зохицуулалтыг бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, харилцагчтай байгуулах гэрээнд тусган хэрэгжүүлж болно. Энэ талаарх зохицуулалтыг дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртөө тусгаж хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг дотоод хяналтын нэгжээр дамжуулан хэрэгжүүлэхээр тусгаж болно.

5. **Сургалт**

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хориг арга хэмжээний талаарх ерөнхий ойлголт, түүнтэй холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэл, тэдгээрийг таньж мэдэх, урьдчилан сэргийлэх арга

хэмжээ, байгууллагын баримтлах бодлого, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын зохицуулалтыг сургалтын хөтөлбөртөө тусгана. Энэ хүрээнд ажилтнуудын чиг үүрэг, ажлын байрны онцлогт тохирсон сургалт, мэдээлэл өгөх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, холбогдох шинэ мэдээлэл, анхааруулгыг цаг тухайд нь хүргэж ажиллах нь эрсдэлийг үр дүнтэй удирдахад чухал алхам болно.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА